



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журмын заалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 75 дугаар зүйлийн 75.2, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/105 дугаар захирамж, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2 дахь заалтыг “Долоо хоногийн даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан гариг ажлын өдрүүд бөгөөд ажил өглөөний 8.30 цагт эхэлж, орой 17.30 цагт дуусна. Ажлын өдрийн амралтын завсарлагааны үргэлжлэх хугацаа 12.30-13.30 цагийн хооронд байна” гэж өөрчлөлт оруулсугай.

2. Уг заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг газрын нийт ажилтнуудад даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2013 оны 30 дугаар тушаалын хавсралтын 4.2 дэхь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

